



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 08 өдөр Дугаар 03

Эрдэнэт

“Өвлийн спортыг хөгжүүлэх”  
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны Эзлжит III хуралдааны 01 дүгээр тогтооолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Өвлийн спортыг хөгжүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр гарган, шаардагдах төсөв, хөрөнгийг тухайн жилийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн төсөвт тусган батлуулж, гадаад дотоодын төсөл хөтөлбөрүүдээс санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг хайх, биелэлтийн явцыг жил бүрийн III улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.



079110320

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны  
01 дүгээр сарын 01-ны өдрийн  
01 дугаар тогтоолын хавсралт

ӨВЛИЙН СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ  
ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлберийн хэрэгцээ, үндэслэл:

Сүүлийн жилүүдэд улс орны хотжилт, техник, технологийн хөгжилтэй холбоотойгоор суурин иргэншил давамгайлж, хүн амын амьдралын хэв маяг болон хөдөлмөр эрхлэлт, соёл иргэншилд гарч байгаа өөрчлөлт нь хүний идэвхтэй хөдөлгөөнийг хязгаарлах, хөдөлгөөний хомсдолтой өвчлөл, эндэгдэл нэмэгдэхэд хүргж байна.

Орхон аймагт хүн ам, ялангуяа хүүхэд, залуучуудын дунд биеийн тамир, спортоор хичээллэх сонирхол нэмэгдэж, биеийн тамир, спорт чийрэгжүүлэлтийн талаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан байгууллагууд тодорхой санаачилга өрнүүлж байгаа боловч үүнд өвлийн спортоор хичээллэгчид маш бага хувийг эзэлдэг.

2018 оны статистик судалгаагаар аймгийн хэмжээнд спортын 47 төрлийн спорт, чийрэгжилтийн секцэнд ёсвэр үе, залуучууд, насанд хүрэгчдийн ангиллаар нийт 24500 хүн хичээллэдгээс өвлийн спортын 5 төрөл /цана, тэшуур, хоккей, мөсний шагай, месөн сур/ нийт 1400 хүн хичээллэж байгаа нь хичээллэгчдийн 5,7% байна.

Иймд өвлийн спортыг орон нутагт хөгжүүлснээр хичээллэгчдийн тоо нэмэгдэж, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй хөдөлгөөнд хамрагдах, эрүүл агаарт гарах, биеийн илүүдэл жин, таргалалтаас урьдчилан сэргийлэх, тамирчид дасгалжуулагч нарын ур чадвар нэмэгдэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, өвлийн спортын орчин нөхцөл сайжрах ач холбогдолтой.

Хөтөлбэрийг боловсруулахдаа Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны 27 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоол “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”, 2019 оны 335 дугаар тогтоол “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай”, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтооюур батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, Орхон аймаг Эрдэнэт хотын “Ногоон тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2025”, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын бичиг баримт, бичгүүдийг үндэс болгов.

Хоёр. Өнөөгийн байдал

Орхон аймгийн хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо нэмэгдэж байгаа боловч үүнээс өвлийн спортын тэрлөөр

хичээллэгчдийн тоо бага, багшлах боловсон хүчин дутмаг, хичээллэх орчин нөхцөл, хэрэглэл материал хангалтгүй байна.

Манай аймагт өнөөдрийн байдлаар өвлийн спортын төрлөөр Мөсний шагайн "Мөнгөн толь" холбоо, хоккейн холбоо үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд өвлийн улиралд Эрдэнэт үйлдвэр ТӨХК-ийн Сархиа цанын бааз 1, мөсөн гулсуурьын 3 талбайд тамирчид бэлтгэл сургуултлаа хийж, иргэд, хүүхэд багачууд чөлөөт цагаа өнгөрөөж байгаа нь 100.0 гаруй хүн амтай манай аймагт мөсөн гулсуур, цанын талбай дутгдалтай байгааг харуулж байна.

Цаашид мэргэжлийн багш, дасгалжуулагч нарыг дэмжин ажиллуулах, хэрэглэл материал, орчин нөхцөл, зам талбайг тохижуулах, нэмэгдүүлэх, шинээр хөгжиж байгаа спортын төрлүүдийг дэмжих төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж хамтран ажиллах шаардлагууд гарч байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго:

Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийг дэмжих, өвлийн спортын төрлийг хариуцсан мэргэжлийн боловсон хүчинийг бэлтгэх, тамирчид, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бэлтгэл, сургуулт хийх стандартын шаардлага хангасан зам талбайг тохижуулж таатай орчинг бий болгох.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт:

4.1. Өвлийн спорт болон нийтийн биеийн тамирыг нийтэд сурталчлах, чийрэгжүүлэлтийн зөв дадал олгох, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх.

4.2. Аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, оролцуулах нөхцөл бололцоогоор хангах.

4.3. Орон нутагт өвлийн спортын мэргэжлийн боловсон хүчинийг тогтвортой суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах.

4.4. Өвлийн спортын төрлөөр хичээллэх орчинг бүрдүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх.

Тав. Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хийх үндсэн үйл ажиллагаа

5.1. **Өвлийн спорт болон нийтийн биеийн тамирыг нийтэд сурталчлах, чийрэгжүүлэлтийн зөв дадал олгох, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх.**

5.1.1. Өвлийн спортын секц дугуйлангуудын төрөл, тоог нэмэгдүүлэх;

5.1.2. Үндэсний спортын төрөл болох мөсний шагай, мөсөн сурын спортыг хөгжүүлэх, шинэ залуу тамирчдыг бэлтгэх;

5.1.3. Өвлийн спортын чиглэлээр улсын болон бусийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах,

5.1.4. Аймаг, орон нутгаас төрөн гарсан ахмад багш болон шилдэг тамирчидаа алдаршуулах, сургалт зохион явуулах, сурталчиллах ажлыг зохион байгуулах;

5.1.5. Өвлийн спортын хувцас, хэрэглэл, материал оёдог, зардаг спорт барааны дэлгүүр, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг дэмжих, хамтран ажиллах

**5.2. Аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын ур чадварыг дээшилүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, оролцуулах нөхцөл бололцоогоор хангах**

5.2.1. Жил бүр өвлийн спортын 3-4 төрлөөр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулж хэвших;

5.2.2. Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бусад аймаг, сумын баг тамирчидтай хамтарсан туршлага солилцох уулзалт, нөхөрсөг тэмцээн болон сэргэлтийн бэлтгэлийг зохион байгуулах;

5.2.3. Тамирчдын запгамж халааг бэлтгэх зорилгоор төрөлжсөн сургалттай спортын дунд сургуульд жил бүр цана, тэшүүрийн тамирчдын элсэлт авах

5.2.4. Дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчдыг жил бүр урамшуулах;

**5.3. Орон нутагт өвлийн спортын мэргэжлийн боловсон хүчинийг тогтворт суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бурдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах.**

5.3.1. Ерөнхий боловсролын сургуулиудад Биеийн тамирын багшийг өвлийн спортын төрөл хариуцуулж ажиллуулах, богино хугацааны сургалтаар мэргэшүүлж, чадавхижуулах;

5.3.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, спортын клуб, холбоодтой хамтран ажиллах;

5.3.3. Өвлийн спортыг хөгжүүлэх чиглэлээр идэвхи санаачилгатай, амжилттай ажиллаж байгаа багш дасгалжуулагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх;

**5.4. Өвлийн спортын төрлөөр хичээллэх орчинг бурдүүлэх, материвааллаг баазыг нэмэгдүүлэх.**

5.4.1. Тамирчид, хүүхэд багачууд, иргэдийн бэлтгэл сургуулилт хийх чөлөөт цагаа өнгөрүүлэх цанын зам, тэшүүр, хоккейн талбайд мөс тавих;

5.4.2. Спорт амралтын хүрээлэнгийн төв асар болон Орос сургуулийн гаднах хоккейн талбайд тамирчдын хувцас солих дулаан өрөө, танхимиг тохижуулах;

5.4.3. Тамирчдын бэлтгэл сургуулилт болон хичээлийн хөтөлбөрт ашиглах цана, тэшүүр, хэрэглэл материалыаар хангах;

5.4.4. Эрдэнэт үйлдвэр төрийн өмчтэй үйлдвэрийн газрын Хангарьд спорт цогцолборын дэргэдэх хоккейн талбайд битүү дээвэртэй мөсөн талбай бүхий ордон байгуулах;

Зургаа.Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа:

Хөтөлбөрийг 2020-2023 онд хэрэгжүүлнэ.

Долоо.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт,

хяналт, шинжилгээ үнэлгээ;

7.1. Хөтөлбөрийг Төрийн захиргааны болон төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүлж нэгтгэлийг Биеийн тамир, спортын газар хариуцаж хяналт шинжилгээ үнэлгээг

аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хийнэ.

7.2.Хөтөлберийн санхүүжилтийг хөтөлбөрт заасан бодлого, төлөвлөгөөнд үндэслэн батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, хөтөлберийн явц, үр дунг жил бүрийн III улиралд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.

Найм. Хөтөлберийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

8.1.Хөтөлберийг хэрэгжүүлэхэд орон нутгаас шаардагдах хөрөнгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, санхүүжүүлнэ;

8.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

8.3.Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр;

8.4.Бусад эх үүсвэр.

Ес. Хөтөлберийн үр дүн, шалгуур үзүүлэлт:

9.1.Иргэд, байгууллага, хамт олон, тамирчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн өвлийн спортын зам, мөсөн талбайг тохижуулж ашиглалт сайжирч, хичээллэх орчин нөхцөл бүрдэж спортоор хичээллэгч, иргэдийн тоо нэмэгдэнэ.

9.2.Тэмцээн уралдааныг тогтмол зохион явуулж, улсын чанартай тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, ёсверийн шигшээ багийн тамирчдын амжилт ахисан байна.

9.3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын спорт хариуцсан арга зүйч болон ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамирын багшийг өвлийн спортын төрөл хариуцуулж ажиллуулах, богино хугацааны сургалтаар мэргэшүүлж, чадавхижуулсан байна.

9.4.Тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор төрөлжсөн сургалттай спортын дунд сургуульд жил бүр цана, тэшүүрийн тамирчдын элсэлт авна.